



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 693

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 23,999,850.00 (хорин гурван сая есөн зуун ерэн есөн мянга найман зуун тавин) төгрөгийн балансын үнэ 3,157,875.00 (гурван сая нэг зуун тавин долоон мянга найман зуун далан таван) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Дагдан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх Нарийн бичгийн дарга О.Амгаланбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Дагдан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх Нарийн бичгийн дарга О.Амгаланбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132007520

\Huraldaanii material\2021 on\2021.12.30 24-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
69... дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Балансын үнэ	Хуриmtлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			(төгрөг)		
1	Сургалтын төвийн цахилгаан хангамж шугам сүлжээ АТП- 3401, 100Ква	2018.12.31	23,999,850.00	3,157,875.00	20,841,975.00
	Нийт дүн		23,999,850.00	3,157,875.00	20,841,975.00
			(хорин гурван сая есөн зуун ерэн есөн мянга найман зуун тавин)	(гурван сая нэг зуун тавин долоон мянга найман зуун далан таван)	(хорин сая найман зуун дөчин нэгэн мянга есөн зуун далан таван)